



ТАВАНТОЛГОЙ ХК

ӨМНӨГОВЬ АЙМАГ
“ТАВАНТОЛГОЙ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 02 сарын 12 өдөр

Дугаар 11

Цогтцэций сум

Ногдол ашиг хуваарилах тухай

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 46.2, 46.5, 46.8 дахь хэсэг, 76 дугаар зүйлийн 76.1.12 дахь заалт, “Тавантолгой” ХК-ийн дүрмийн Долоогийн 7.4.11, Арван хоёрын 12.1, 12.2.1 дэх заалтыг үндэслэн “Тавантолгой” ХК-ийн Төлөөлөн Удирдах зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. “Тавантолгой” ХК-ийн 2024 оны татвар төлсний дараах цэвэр ашгаас ногдол ашиг болгон нэгж хувьцаанд 6960 (зургаан мянга есөн зуун жар) төгрөг хуваарилахаар тогтоосугай.

2. Ногдол ашиг авах эрхтэй Хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг гаргах бүртгэлийн өдрийг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдрөөр тогтоосугай.

3. Ногдол ашгийг холбогдох хууль тогтоомжийн дагуу Хувьцаа эзэмшигчдэд 2025 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн мөнгөн хэлбэрээр тараасугай.

4. Тогтоолын хэрэгжилтийг хангаж, холбогдох гэрээ хэлцэл байгуулах, төлбөр тооцоо хийх, тайлан мэдээг Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж ажиллахыг гүйцэтгэх захирал (Ч.Гүнждагва)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ш.ОТГОНБАЯР